



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХӨВСГӨЛ АЗЗА ТӨХК-ИЙН
2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТ

Аудитын код: САГ-2018/132/СТА-ТӨҮГ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2018 он



“ХӨВСГӨЛ АЗЗА” ТӨХК-ИЙН
ЗАХИРАЛ Г.ГАЛБАДРАХ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018.03.15 № 06/743
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хөвсгөл АЗЗА” ТӨХК–ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Хөвсгөл АЗЗА” ТӨХК– ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Хөвсгөл АЗЗА” ТӨХК– ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

11/10.10.10.20 Bichig_KheregiYawsan_Batbayar 2018.03.15 17:54:57 UTC+8

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

071220


Үүрэг, хариуцлага

“Хөвсгөл АЗЗА” ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



\\10.10.10.20\Bichig_Kherel\Yawsan_Bichig\2018\0315SAG79.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

“Хөвсгөл АЗЗА” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийж тайлангийн дүгнэлтийг “Хөвсгөл АЗЗА” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Г.Галбадрах болон ТУЗ-д танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, зорилтод түвшин, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг тодорхойлсон болно.

3. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага


Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хөвсгөл АЗЗА” ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд.ҮАГ/САГ-2018/112/СТА/ТӨҮГ санхүүгийн тайлангийн аудит хийв.

Аудитыг Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын Олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Хөвсгөл АЗЗА” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Хөвсгөл АЗЗА” ТӨХК-ийн санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/-тай нийцүүлж материаллаг алдаагүй нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, зорилтод түвшингийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



Аудитыг 2018 оны 02 дугаар сарын 25-наас 2018 оны 03 дугаар сарын 15-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 03 дугаар сарын 15-нд эцэслэн баталгаажуулж “Хөвсгөл АЗЗА” ТӨХК-ийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн “Си Эс Ай Аудит” ХХК-ийн партнер М.Сэвжидмаа хариуцаж аудитын баг төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу санхүүгийн тайлангийн аудитыг хэрэгжүүлэв.

4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу тус компанийн гүйцэтгэх захирал өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж явуулж байна.

“Хөвсгөл АЗЗА” ТӨХК нь төрийн захиргааны төв байгууллагатай байгуулсан “Зам засвар, арчлалтын гэрээ”-ний дагуу улсын чанартай авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтыг Хөвсгөл аймгийн хэмжээнд зохион байгуулж түүгээр өнгөрч байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг жилийн туршид саадгүй байлгах үүргийг бүрэн хангаж ажиллаж байна.

“Хөвсгөл АЗЗА” ТӨХК нь авто зам засвар, арчлалтын үйл ажиллагааг гүйцэтгэхдээ холбогдох эрх бүхий байгууллагаас баталсан авто замын урт, тэдгээрийн дагуу байрлах, шугаман албадан байршил, засвар арчлалтын нэгж, норм норматив, төсвийн норм, үнэлгээ болон түрээсийн тоног төхөөрөмжийн машин цагийн норм үнэлгээг мөрдөж ажиллаж байна.

Тайлант онд Авто замын тухай хууль өөрчлөгдсөн бусад хууль, тогтоомж түүнд нийцүүлэн гаргасан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна

5. Аудитын шалгуур үзүүлэлт, АРГА зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын Олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт 1000-1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, Санхүүгийн тайлагналын Олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.


Аудитаар “Хөвсгөл АЗЗА” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлангийн уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлснээс гадна тус байгууллагын удирдлагаас тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансыг түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 15-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

“Хөвсгөл АЗЗА” ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

“Хөвсгөл АЗЗА” ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн MACS программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Тухайн жилд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй болно.



6. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцов.

“Хөвсгөл АЗЗА” ТӨХК-ийн төлөвлөлтийн үе шатанд материаллаг түвшинг 2016 оны 811.9 сая төгрөгийн нийт орлогоос хоёр хувь 16.2 сая төгрөгөөр тооцож төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд 2017 оны нийт орлого 964.4 сая төгрөгөөс хоёр хувь 19.3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа. /ТАБ-СТА-В-1/

7. Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. “Хөвсгөл АЗЗА” ТӨХК-ийн дотоод хяналт байхгүй зөвхөн Хөвсгөл аймгийн төрийн сангийн хэлтэс 2017 оны шилэн дансны хэрэгжилтэнд шалгалт хийсэн мөн ТӨБЗГ-аас 2017 онд 2015-2016 оны санхүүгийн болон үйл ажиллагаанд шалгалт хийсэн байна.

8. Орлого, зардлын талаар:

“Хөвсгөл АЗЗА” ТӨХК-ийн 2017 оны эдийн засгийн зорилтод түвшинг ТӨБЗГ-ын баталсан. Орлогын төлөвлөгөө 705.0 сая төгрөгөөр баталснаас, 964.4 сая төгрөгийн орлогын гүйцэтгэлтэй ажиллаж 259.4 сая төгрөгөөр давж биелсэн, нийт зардал 698.5 сая төгрөг батлагдсанаас 953.2 сая төгрөгийн зардал гарсан байна.

9. Шилэн дансны мэдээлэл

“Хөвсгөл АЗЗА” ТӨХК нь Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн захирагчийн шийдвэр, үйл ажиллагаа ил тод нээлттэй, ойлгомжтой байхад нийцүүлэн <http://shilehdans.gov.mn/> сайтад батлагдсан маягт, хавсралтуудын дагуу төсөв, гүйцэтгэл худалдан авах ажиллагаа, гаргасан гүйлгээний мэдээлэл, санхүүгийн тайлан тэнцэлийн мэдээллийг тогтмол сар бүр байршуулсан байна.

10. Олж тогтоосон эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 15 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 15 хяналтын болон нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

11. Гол онцлог гүйлгээний талаарх тайлбар

“Хөвсгөл АЗЗА” ТӨХК-ийн хувьд 2017 онд гол онцлох гүйлгээ байхгүй болно.

12. Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

“Хөвсгөл АЗЗА” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах алдаа, зөрчил илэрснийг доорх байдлаар шийдвэрлэсэн болно. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 1985 онд ашиглалтанд орсон 17.3 сая төгрөгийн дансны үнэтэй конторын барилга хөрөнгийн маргаантай асуудлаас шалтгаалан “Хөвсгөл Зам” ХХК-д ашиглагдаж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6.. “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”,.. гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь

Барилгын эзэмшлийн маргааныг хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх зөвлөмж өгөв.

2. Дуусаагүй барилга дансанд 2009 онд үүссэн 64.8 сая төгрөгийн конторын зориулттай дуусаагүй барилга бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6.. “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”,.. гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь

Дуусаагүй барилгыг цаашид ашиглах боломжгүй тул холбогдох буруутай талаар хохирол нөхөн төлүүлэх, данснаас хасах арга хэмжээ авах.

3. Газар шорооны ажил хийх үед зураг төсөвт заагдсан болон хөдөлмөрийн аюулгүй байдал хангаагүйгээс холбооны кабель гэмтээсний 3 удаагийн торгуулийн арга хэмжээ авагдан 2.0 сая төгрөгийг зарцуулсан боловч буруутай албан тушаалтанд арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь

Хохирлыг буруутай этгээдээр төлүүлж байхаар албан шаардлага өгөв.

13. АНХААРАЛ ТАТАХУЙЦ ЧУХАЛ АСУУДЛУУД

Байхгүй болно.

14. МАТЕРИАЛАГ БУС ЗАЛРУУЛАГДААГҮЙ АЛДААНУУДЫН ТАЛААРХ ТАЙЛБАР

2017 оны санхүүгийн тайланд үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 84.1 сая төгрөгийн барилгыг зохих журмын дагуу шийдвэрлүүлэхийг зөвлөв.

15. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд байхгүй болно



16. Санхүүгийн тайланд аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

“Хөвсгөл АЗЗА” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 84.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 84.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

17. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2016 онд “Мишээл-Од Аудит” ХХК нь санхүүгийн тайлангийн аудит хийж аудитаар 3 албан шаардлага, 4 зөвлөмж өгсөнийг 100 хувь биелүүлсэн байна.

18. ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй санал дүгнэлт

“Хөвсгөл АЗЗА” ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 17 хуудас, хавсралтууд хуудас, байгууллагын санал .. хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

“СИ ЭС АЙ АУДИТ” ХХК-ИЙН
ПАРТНЕР:
АХЛАХ АУДИТОР:
БЭЛТГЭСЭН: АУДИТОР:



М.СЭВЖИДМАА
С.СОДНОМЦЭРЭН
Д.ЧУЛУУНБАТ



“Хөвсгөл АЗЗА” ТӨХК
2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН



МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

“СИ ЭС АЙ АУДИТ” ХХК
Хаяг: УБ хот Чингэлтэй дүүрэг
4-р хороо Цэцээ гүн төв 206 тоот
Утас: 70001981, 99096584
Зөвлөх үйлчилгээ:
Утас: 19001981

Тэргүүлэх ач холбогдол № 1
Асуудал 1 Үндсэн хөрөнгө.....

Тэргүүлэх ач холбогдол № 2

19. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын Олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.


Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



1. Үндсэн хөрөнгө	Тэргүүлэх ач холбогдол №1
--------------------------	----------------------------------

АЖИГЛАЛТ

1. Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 1985 онд ашиглалтанд орсон 17.3 сая төгрөгийн дансны үнэтэй конторын барилга хөрөнгийн маргаантай асуудлаас шалтгаалан “Хөвсгөл Зам” ХХК-д ашиглагдаж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6. “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”;.. гэсэн заалтыг зөрчиж байна.
2. Дуусаагүй барилга дансанд 2009 онд үүссэн 64.8 сая төгрөгийн конторын зориулттай дуусаагүй барилга бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6. “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”;.. гэсэн заалтыг зөрчиж байна.

ЭРСДЭЛ

Хөрөнгө санхүүгийн тайланд буруу илэрхийлэгдэх.
Хөрөнгө шамшигдах.
ЭҮ, ИБ, Х,ТИ, ОБ,ҮЗ батламж мэдэгдэл хангахгүй байна.

ЗӨВЛӨМЖ

1. Барилгын эзэмшлийн маргааныг хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх зөвлөмж өгөв.
2. Дуусаагүй барилгыг цаашид ашиглах боломжгүй тул холбогдох буруутай талаар хохирол нөхөн төлүүлэх, данснаас хасах арга хэмжээ авах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 01-ны дотор ҮАГ-т бичгээр ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Дээрх зөвлөмжийг цаашид үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах болно.


АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

“СИ ЭС АЙ АУДИТ” ХХК-ийн
ПАРТНЕР:
АХЛАХ АУДИТОР:
БЭЛТГЭСЭН: АУДИТОР:



М.СЭВЖИДМАА
С.СОДНОМЦЭРЭН
Д.ЧУЛУУНБАТ



АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	АУДИТ ХИЙГДСЭН	
		2016 оны 12 сарын 31	2017 оны 12 сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	42,966,061.01	17,344,007.26
1.1.2	Дансны авлага	183,071,000.00	170,218,999.59
1.1.6	Бараа материал	13,421,927.90	26,176,636.39
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/гооцоо	51,935,214.46	51,935,214.46
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	291,394,203.37	265,674,857.71
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	324,656,566.55	328,422,232.93
1.2.2	Биет бус хөрөнгө	693,000.00	462,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	325,349,566.55	328,884,232.93
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	616,743,769.92	594,559,090.63
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	53,426,636.00	71,500,180.41
2.1.1.2	Цалингийн өглөг	845,001.00	(0.00)
2.1.1.3	Татварын өр	49,632,649.88	29,682,903.24
2.1.1.4	НДШ - ийн өглөг	199,721.70	1,195,126.47
2.1.1.5	Банкны богино хугацаат зээл	29,750,000.00	
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	133,854,008.58	102,378,210.12
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	448,747,239.00	448,747,239.00
2.1.2.5			
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	448,747,239.00	448,747,239.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	582,601,247.58	551,125,449.12
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	198,107,930.75	198,107,930.75
2.3.2	- хувийн	-	-
2.3.3	- хувьцаат		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	10,753,300.00	10,753,300.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	171,130,471.00	171,130,471.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(345,849,114.31)	(336,558,060.24)



2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	34,142,587.44	43,433,641.51
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	616,743,835.02	594,559,090.63

АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

/Төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	АУДИТ ХИЙГДСЭН	
		2016 оны 12 сарын 31	2017 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	811,912,059.13	964,371,043.34
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	704,510,495.25	860,265,512.15
3	Нийт ашиг (алдагдал)	107,401,563.88	104,105,531.19
10	Ерөнхий ба удирдлагын зардал	64,629,235.90	87,681,676.54
11	Санхүүгийн зардал	11,907,868.79	4,711,113.57
12	Бусад зардал	6,852,056.10	517,508.67
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(14,715,909.09)	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	9,296,494.00	11,195,232.41
19	Орлогын татварын зардал	1,614,855.01	1,119,523.24
20	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	7,681,638.99	10,075,709.17
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	7,681,638.99	10,075,709.17
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	7,681,638.99	10,075,709.17
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		



АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛГИЙН ТАЙЛАН

/ төгрөг/

АУДИТ ХИЙГДСЭН										
№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нооц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн	
1	2016 оны 12 сарын 31	198,107,930.75			10,753,300.0		619,877,710.0	(345,849,114.31)	482,889,826.44	
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлийн нөлөө, алдааны залруулга			-					-	
3	Залруулсан үшгэдэл									
4	Тайланг үеийн цэвэр ашиг (алдагдал)									
5	Бусад дэлгэрэнгүй орлого									
6	Өмчид гарсан өөрчлөлт									
7	Зарласан ногдол ашиг									
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн									
9	2016 оны 12 сарын 31	198,107,930.75	-	-	10,753,300.0	-	619,877,710.0	(345,849,114.31)	482,889,826.44	
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлийн нөлөө, алдааны залруулга								-	
11	Залруулсан үшгэдэл							(345,849,114.31)	482,889,826.44	
12	Тайланг үеийн цэвэр ашиг (алдагдал)							10,075,709.17	10,075,709.17	
13	Бусад өөрчлөлийн үр орлого								-	
14	Өмчид гарсан өөрчлөлт								-	
15	Зарласан ногдол ашиг							784,590.00	784,590.00	
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								-	
17	2016 оны 12 сарын 31	198,107,930.75	-	-	10,753,300.0	-	619,877,710.0	(336,557,995.14)	492,180,945.61	


ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

01
ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөг/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	АУДИТ ХИЙГДСЭН	
		2016 оны 12 сарын 31	2017 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	804,618,803.78	1,003,759,151.79
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	797,279,765.39	953,340,964.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	836,019.00	85,683.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	6,503,019.39	50,332,504.79
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	814,194,969.37	939,202,207.42
1.2.1	Ажиллагчдад төлсөн	323,979,063.10	320,601,113.97
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	41,386,339.34	69,615,584.95
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	91,375,450.00	183,844,612.22
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	35,840,078.00	87,797,317.20
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	202,694,281.00	126,158,829.20
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	6,175,372.05	0.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	64,100,699.88	124,927,674.82
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	531,075.00	118,800.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	48,112,611.00	26,138,275.06
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(9,576,165.59)	64,556,944.37
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,800,000.00	42,100,000.00
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	2,800,000.00	-
2.1.5	Бусад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	42,100,000.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	6,191,000.00	97,257,916.78
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	6,191,000.00	88,352,843.78
2.2.5	Бусад олгосон зээл болон урьдчилгаа	-	8,905,073.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(3,391,000.00)	(55,157,916.78)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	94,000,000.00	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	94,000,000.00	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	38,418,043.05	35,021,081.34
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	37,715,093.05	34,236,491.34
3.2.4	Төлсөн ногдол ашиг	702,950.00	784,590.00




“Хөвсгөл АЗЗА” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

3.2.5	торгууль	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	55,581,956.95	(35,021,081.34)
4	Валютын ханшийн зөрүү	-	-
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	42,614,791.36	(25,622,053.75)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	351,299.94	42,966,061.01
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	42,966,061.01	17,344,007.26

АУДИТОР



Д.ЧУЛУУНБАТ




АУДИТ ХИЙГДСЭН 2017 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ
ТҮВШИНГИЙН БИЕЛЭЛТ

д.д	Үзүүлэлт	хэмжих нэгж	2017		Харьцуулалт	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хувь	зөрүү
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэл	м.төг	705,000.0	964,370.8	136.8	259,370.8
	а/ Улсын чанартай зам засвар арчлалт	м.төг	500,000.0	472,068.6	94.4	(27,931.4)
	б/Орон нутгийн чанартай зам засвар, барилгын ажил	м.төг	205,000.0	437,027.0	213.2	232,027.0
	в/ Бусад орлого	м.төг	-	55,275.2		55,275.2
2	НИЙТ ОРЛОГО	м.төг	705,000.0	964,370.8	136.8	259,370.8
3	НИЙТ ЗАРДАЛ	м.төг	698,526.8	953,175.8	136.5	254,649.0
	Үүнээс: Удирдлагын зардал	м.төг	157,391.0	147,671.8	93.8	(9,719.2)
4	Татварын өмнөх ашиг	м.төг	6,473.2	11,195.2	172.9	4,722.0
5	Цэвэр ашиг /алдагдал/	м.төг	5,825.9	10,075.7	172.9	4,249.8
6	Төсвийн төлбөрт нийт дүн	м.төг	65,256.1	126,160.6	193.3	60,904.5
	а/Орлогын татварт	м.төг	1,240.0	314.9	25.4	(925.1)
	б/ НӨТ	м.төг	20,235.1	50,779.0	250.9	30,543.9
	в/НДШ	м.төг	21,921.0	51,557.9	235.2	29,636.9
	г/Хүн амын орлогын татварт	м.төг	19,890.0	21,165.8	106.4	1,275.8
	д/Үл хөдлөхийн татварт	м.төг	680.0	680.0	100.0	-
	е/Гаалийн татварт	м.төг	-	-		-
	ж/Тээврийн хэрэгслийн татварт	м.төг	1,290.0	752.0	58.3	(538.0)
	и/Бусад татварт /Газрын төлбөр/	м.төг	-	911.0		911.0
7	Төрийн өмчийн ноогдол ашигт	м.төг	784.5	784.5	100.0	-
8	Нийт ажиллагсдын тоо	м.төг	37	38	102.7	1.0
9	Нийт цалингийн сан	м.төг	178,960.0	281,028.7	157.0	102,068.7
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	м.төг	4,709.4	7,395.5	157.0	2,686.1
13	Борлуулалтын 1 төг-т ноогдох зардал	м.төг	0.99	0.99	99.8	(0.0)
14	Хөрөнгө оруулалт	м.төг	80,000.0	79,800.0	99.8	(200.0)
15	НИЙТ АВЛАГА	м.төг	62,000.0	170,219.0	274.5	108,219.0
	Үүнээс:Найдваргүй	м.төг		-		-
16	НИЙТ ӨГЛӨГ	м.төг	35,200.0	102,378.0	290.8	67,178.0
	Үүнээс: Богино хугацаат	м.төг	35,200.0	102,378.0	290.8	67,178.0
	урт хугацаат	м.төг				

АУДИТОР



Д.ЧУЛУУНБАТ



Санхүүгийн тайлангийн аудитын хураангуй
тайлан

Огноо 2018 оны 03 сарын 14

Нэг. Ерөнхий мэдээлэл

Аудитын код:	ҮАГ-САГ/2018/113/СТА-ТӨҮГ	Шалгасан байгууллага, нэгжийн нэр:	"Хөвсгөл АЗЗА" ТӨХК
Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр:	"Си Эс Ай Аудит" ХХК	Аудит хийсэн баг, албан тушаалтан	Партнер М.Сэвжидмаа аудитор, С.Содномцэрэн, аудитор С.Цэнд-Аюуш, аудитор Д.Чулуунбат, аудитын ЧХМ Р.Батмөнх
Аудитын нэр:	"Хөвсгөл АЗЗА" ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан, зорилтод түвшинд		

Хоёр. Байгууллага, нэгжийн тоо болон санал дүгнэлтийн талдаарх мэдээлэл

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр/ангилал	Байгууллага, нэгжийн тоо					Гаргасан санал дүгнэлтийн хэлбэр		
		Аудит хамрагдах	Аудит хийсэн хэлбэр				зөрчилгүй санал		
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт	Итгэл үзүүлсэн	Аудит хийгээгүй			
A	1	2	3	4	5	6	7	8	9
1	"Хөвсгөл АЗЗА" ТӨХК	1	1				1		

Гурав. Аудитын үр дүн

2.1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төг/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа зөрчлийн		Үүнээс			
		тоо	дүн	Зөвлөмж	Төлбөрийн акт	Албан шаардлага	Хууль хяналтын бусад байгууллагад шилжүүлсэн
1	"Хөвсгөл АЗЗА" ТӨХК	4	249.2	3	247.2	1	2.0

2.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг ач холбогдлоор нь эрэмбэлж танилцуулах:

Алдаа, зөрчилтэй асуудал 1



1. Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 1985 онд ашиглалтанд орсон 17.3 сая төгрөгийн дансны үнэтэй конторын барилга хөрөнгийн маргаантай асуудлаас шалтгаалан “Хөвсгөл Зам” ХХК-д ашиглагдаж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6. “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”;.. гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь:

1. Барилгын эзэмшлийн маргааныг хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх зөвлөмж өгөв.

Алдаа, зөрчилтэй асуудал 2

. Дуусаагүй барилга дансанд 2009 онд үүссэн 64.8 сая төгрөгийн конторын зориулттай дуусаагүй барилга бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6. “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”;.. гэсэн заалтыг зөрчиж байна.




Шийдвэрлэсэн нь:


2. Дуусаагүй барилгыг цаашид ашиглах боломжгүй тул холбогдох буруутай талаар хохирол нөхөн төлүүлэх, данснаас хасах арга хэмжээ авах.

2.3. Аудитын санал дүгнэлтийн үндэслэл

“Хөвсгөл АЗЗА” ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Гурав. Баталгаажуулалт

Тайлангийн хураангуй бэлтгэсэн: Аудитор  Д. Чулуунбат
Анхан шатны чанарын хяналт хийсэн: Ахлах аудитор  С. Содномцэрэн
Хоёр дах шатны чанарын хяналт хийсэн: Партнер  М. Сэвжидмаа



АУДИТЫН ЯВЦАД ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Байгууллагын нэр: ХӨВСГӨЛ АЗЗА ТӨХК

Код: УАГ-САГ/2018/112/СТА-ТӨҮГ

/сая төгрөг/

№	Аудитын зорилт чиглэл	Тоо	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
					Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5	6	7		
1	"Хөвсгөл АЗЗА" ТӨХК-ийн санхүүгийн тайлангийн аудит	1	1. Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 1985 онд ашиглалтанд орсон 17.3 сая төгрөгийн дансны үнэтэй конторын барилга хөрөнгийн маргаантай асуудлаас шалтгаалан "Хөвсгөл Зам" ХХК-д ашиглагдаж	17.3 Зөвлөмж өгөв				Гүйцэтгэх захирал Нягтлан бодогч	Б.Галбадрах Б.Цэрэнсүрэн
2	"Хөвсгөл АЗЗА" ТӨХК-ийн санхүүгийн тайлангийн аудит	2	Дуусаагүй барилга дансанд 2009 онд үүссэн 64.8 сая төгрөгийн конторын зориулттай дуусаагүй барилга бүртгэлтэй байна	64.8 Зөвлөмж өгөв				Гүйцэтгэх захирал Нягтлан бодогч	Б.Галбадрах Б.Цэрэнсүрэн
	Хөвсгөл АЗЗА" ТӨХК-ийн санхүүгийн тайлангийн аудит	3	3. Газар шорооны ажил хийх үед зураг төсөвт заагдсан болон хөдөлмөрийн аюулгүй байдал хангаагүйгээс холбооны кабель гэмтээсний 3 удаагийн торгуулийн арга хэмжээ авагдан 2.0 сая төгрөгийг зарцуулсан боловч буруутай албан тушаалтанд арга хэмжээ авч ажилаагүй байна.	2.0 Албан шаардлага				Гүйцэтгэх захирал Нягтлан бодогч	Б.Галбадрах Б.Цэрэнсүрэн

Тайлангийн хураангуй бэлтгэсэн: Аудитор Д.Чулуунбат
 Анхан шатны чанарын хяналт хийсэн: Ахлах аудитор С.Содномцэрэн
 Хоёр дах шатны чанарын хяналт хийсэн: Партнер М.Сэвжидмаа



АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДЛЫН БҮРТГЭЛ

"ХӨВСГӨЛ АЗЗА" ТӨХК

Огноо: 2017 он

Дд	Сорил хийсэн дансны нэр	Аудитаар илэрсэн асуудал	Санхүүгийн тайданд үзүүлэх нөлөө (Materiality)	Аудиторын санал (Бүртгэлийн бичилт, тооцоолол)	Тухайн байгууллагын санал (Бүртгэлийн бичилт, тооцоолол)	Уулзалтын үр дүнгийн баталгаажуулалт
1	Барилга	Тус байгууллагын конторын барилга 1985 оны 6 дугаар сарын 1 нд ашиглалтанд орсон бөгөөд 2008 онд ХӨВСГӨЛ АЗЗА ТӨХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан Н.Болд-Эрдэнэ нь Хөвсгөл зам ХХК-д нягтлан Өлзий ням балансаас хассан конторын барилга 17.3 сая төгрөгийн өртөгтэй үндсэн хөрөнгөнд дээр бүртгэлтэй өөрийн эзэмшлийн барилга нь бусдын эзэмшилд байна. Тус байгууллагын данс бүртгэлд 3.0 сая төгрөгөөр бүртгэлтэй худаг байна энэ худаг бас хүний эзэмшилд байна. Мэдээлэл холбоо ТӨХК-д танайх 3 удаагийн шилжүүлэгээр хохирлын тооцоо гэж 1.961.0 мянган төгрөгийн хохирол төлсөн байна энэ ямар асуудлаас болж хохирол төлөх болов	Материаллаг бус	Данс бүртгэлд бүртгэлтэй үндсэн хөрөнгө өөрийн эзэмшилд байхгүй байгаа нь хөрөнгөнд тавих хяналт сул байгаагаас бүртгэлтэй хөрөнгө эзэмшилд байхгүй байна.	Өмнөх удирдлагуудын үед худалдсан бөгөөд Хөвсгөл АЗЗА ТӨХК-ийн дараагийн удирдлагууд худалдсан хөрөнгийг балансад дахин бүртгэсэн. АТГ болон бусад байгууллага шалгаад Хөвсгөл зам ХХК-д шийдвэрлэсэн байна. Иймд 2018 онд ТӨБЭЗГ-т хүсэлт явуулж, маргаантай хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлнэ.	Зөвлөмж өгөхөөр
2	Зардал	Ус байгууллага тээврийн зардалд их эмжээний зардал гарч байна үүнд дүн линжилгээ хийж үзэх Асуудлын бүртгэлд хамрагдсан	Материаллаг бус	2017 онд тээврийн зардалд нийт 18.012.500 төгрөг төлсөн бөгөөд ихэнх нь Хөтөлөөс Мөрөн хүртэл цемент татаж авсан зардал юм.	Цаашдаа тээвэрлэлт хийх ХОВО автомашин хөрөнгө оруулалтаар авахаар төлөвлөж байгаа.	Зөвлөмж өгөхөөр

10 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

УЛААНБААТАР 101
Б.Цэрэнсүрэн
С.Содномцэрэн
АУДИТ ХХК
Я.Самбууням
УЗМ03039 5303001

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ